

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2022/127/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа.</p> <p>Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх</p> <p>Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК</p> <p>Утас: 77270808 Цахим хаяг: <a href="mailto:Nitsbalance@gmail.com">Nitsbalance@gmail.com</a></p>
-------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

<u>1. Аудитын санал дүгнэлт</u> .....	3
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u> .....	4-10
<u>3. Аудитын тайлан</u> .....	11
<u>3.1 Ерөнхий зүйл</u> .....	11
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u> .....	11
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u> .....	12
<u>3.4 Материаллаг байдал</u> .....	13
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u> .....	13
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u> .....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.6.3 Нэмэлт төсөв.....	15
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u> .....	15
<u>3.8 Аудитын гол асуудал</u> .....	15
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u> .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15-16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u> .....	16
<u>3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал</u> .....	16
<u>4. Аудитын илрүүлэлт</u> .....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Зөвлөмж.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар



МАНДАЛ СУМЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ж. ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СМА-2022/МАТ-НА-СТТ-743

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>212,833,673.99</b>	<b>210,550,764.97</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,014,179.29</b>	<b>3,354,392.55</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,014,179.29	3,354,392.55
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>208,819,494.70</b>	<b>207,196,372.42</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>44,902,976.53</b>	<b>44,768,076.53</b>
35110	Тусгай зориулалттай материал	44,661,841.53	44,661,841.53
35130	Эм боох материал	241,135.00	106,235.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>163,916,518.17</b>	<b>162,428,295.89</b>
35410	Бичиг хэргийн материал	283,789.68	591,710.00
35420	Аж ахуйн материал	217,900.00	398,650.00
35440	Түлш, шатах тослох материал	5,404,622.00	6,026,980.00
35450	Барилгын засварын материал	3,949,500.00	0.00
35460	Хүнсний материал	2,610,800.00	445,000.00
35470	Бусад хангамжийн материал	151,449,906.49	154,965,955.89
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,341,487,372.15</b>	<b>3,736,721,163.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,341,487,372.15</b>	<b>3,736,721,163.28</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,274,115,497.06</b>	<b>2,668,921,656.19</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,855,808,390.00	2,166,259,068.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-156,070,808.16	-234,106,212.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,750,000.00	6,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,750,000.00	-6,750,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	387,030,216.45	270,642,188.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-324,369,192.91	-45,562,696.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,206,527.10	126,543,599.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-110,158,489.79	-54,925,247.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	505,273,083.98	498,832,867.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	-103,043,946.81	-126,309,623.37
39217	Ном	63,439,717.20	67,547,712.90
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,067,371,875.09</b>	<b>1,067,799,507.09</b>
39301	Програм хангамж	2,837,720.00	2,302,632.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,665,844.91	-703,124.91
39303	Бусад биет бус хөрөнгө	1,066,200,000.00	1,066,200,000.00
<b>3</b>	<b>НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,554,321,046.14</b>	<b>3,947,271,928.25</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,554,321,046.14</b>	<b>3,947,271,928.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,554,321,046.14</b>	<b>3,947,271,928.25</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,367,675,453.39	2,367,675,453.39
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-374,855,721.63</b>	<b>20,381,203.75</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-356,704,279.19	-372,569,678.36
51220	Тайлант үеийн үр дүн	-18,151,442.44	392,950,882.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,561,501,314.38	1,559,215,271.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,554,321,046.14</b>	<b>3,947,271,928.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,829,177,983.02</b>	<b>2,183,272,597.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>105,143,568.52</b>	<b>528,728,612.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>105,143,568.52</b>	<b>528,728,612.98</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	52,625,344.02	515,693,801.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	52,518,224.50	13,034,811.44
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,724,034,414.50</b>	<b>1,654,543,984.22</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,619,090,500.00</b>	<b>1,521,200,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,619,090,500.00	1,521,200,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,941,600.00</b>	<b>14,688,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,941,600.00	2,914,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>101,002,314.50</b>	<b>118,655,584.22</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	101,002,314.50	118,655,584.22
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,847,329,425.46</b>	<b>1,790,245,549.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,847,329,425.46</b>	<b>1,790,245,549.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,740,017,043.77</b>	<b>1,741,005,441.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,285,141,166.54</b>	<b>1,250,467,640.00</b>
210101	Үндсэн цалин	926,026,664.83	824,216,146.86
210102	Нэмэгдэл	225,310,178.06	351,506,978.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	87,653,567.07	74,744,514.45
210105	Гэрээт ажлын хөлс	46,150,756.58	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>156,411,602.76</b>	<b>163,707,851.76</b>
210201	Тэтгэврийн даатгал	109,104,519.25	116,334,021.23
210202	Тэтгэмжийн даатгал	12,668,770.19	12,891,732.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,213,671.57	10,047,945.77
210204	Ажилгүйдлийн даатгал	2,220,420.23	2,221,285.90
210205	Эрүүл мэндийн даатгал	22,204,221.52	22,212,866.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,304,614.50</b>	<b>110,040,904.22</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,984,726.50	23,061,084.22
210302	Түлш, халаалт	62,181,000.00	80,477,300.00
210303	Цэвэр, бохир ус	7,138,888.00	6,502,520.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,506,089.92</b>	<b>29,605,344.78</b>
210401	Бичиг хэрэг	1,689,828.92	1,668,379.68
210402	Тээвэр, шатахуун	1,464,938.00	1,119,222.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,152,073.00	1,918,680.00
210404	Ном, хэвлэл	58,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,967,560.00	2,936,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,172,890.00	3,962,343.50
210408	Бараа материал акталсны зардал	0.00	18,000,219.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,934,935.00</b>	<b>13,599,950.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	378,890.00	1,175,950.00
210502	Хоол, хүнс	14,610,445.00	10,791,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,945,600.00	1,632,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,631,750.00</b>	<b>21,890,350.00</b>
210604	Урсгал засвар	15,631,750.00	21,890,350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>201,170.00</b>	<b>202,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	201,170.00	202,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,179,184.00</b>	<b>9,066,455.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	315,184.00	7,871,255.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	1,195,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>163,706,531.05</b>	<b>142,424,945.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,176,357.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,732,910.00	3,056,201.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,797,264.05	139,368,744.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>107,312,381.69</b>	<b>49,240,107.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,202,200.00</b>	<b>31,131,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,400,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>78,110,181.69</b>	<b>18,108,407.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,110,181.69	18,108,407.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-18,151,442.44</b>	<b>393,027,048.04</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>76,165.93</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	76,165.93
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-18,151,442.44</b>	<b>392,950,882.11</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,367,675,453.39	1,561,501,314.38	-374,855,721.63	3,554,321,046.14
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,367,675,453.39	1,561,501,314.38	-374,855,721.63	3,554,321,046.14

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,286,043.27	2,286,043.27
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,367,675,453.39</b>	<b>1,561,501,314.38</b>	<b>-372,569,678.36</b>	<b>3,556,607,089.41</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-2,286,043.27	0.00	-2,286,043.27
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	392,950,882.11	392,950,882.11
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>2,367,675,453.39</b>	<b>1,559,215,271.11</b>	<b>20,381,203.75</b>	<b>3,947,271,928.25</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,737,159,538.50</b>	<b>1,665,047,763.51</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,737,159,538.50</b>	<b>1,665,047,763.51</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,619,090,500.00</b>	<b>1,521,200,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,619,090,500.00	1,521,200,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>17,066,724.00</b>	<b>25,191,779.29</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	11,774,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,066,724.00	13,417,779.29
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>101,002,314.50</b>	<b>118,655,584.22</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	101,002,314.50	118,655,584.22
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,713,197,138.50</b>	<b>1,646,062,863.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,713,197,138.50</b>	<b>1,646,062,863.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,594,660,977.52</b>	<b>1,588,889,863.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,285,141,166.54</b>	<b>1,250,467,640.00</b>
210101	Үндсэн цалин	926,026,664.83	824,216,146.86
210102	Нэмэгдэл	225,310,178.06	351,506,978.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	87,653,567.07	74,744,514.45
210105	Гэрээт ажлын хөлс	46,150,756.58	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>155,612,702.48</b>	<b>163,707,851.76</b>
210201	Тэтгэврийн даатгал	108,305,618.97	116,334,021.23
210202	Тэтгэмжийн даатгал	12,668,770.19	12,891,732.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,213,671.57	10,047,945.77

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,220,420.23	2,221,285.90
210205	Эрүүл мэндийн даатгал	22,204,221.52	22,212,866.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,333,614.50</b>	<b>111,176,484.22</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,984,726.50	23,061,084.22
210302	Түлш, халаалт	63,210,000.00	81,612,880.00
210303	Цэвэр, бохир ус	7,138,888.00	6,502,520.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,914,623.00</b>	<b>15,123,232.50</b>
210401	Бичиг хэрэг	1,571,950.00	1,976,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,732,200.00	606,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,152,073.00	1,918,680.00
210404	Ном, хэвлэл	58,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,028,800.00	1,619,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,370,800.00	9,003,252.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,047,350.00</b>	<b>17,017,650.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	421,570.00	1,041,050.00
210502	Хоол, хүнс	14,920,590.00	10,536,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,705,190.00	5,439,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,790,700.00</b>	<b>18,146,600.00</b>
210604	Урсгал засвар	17,790,700.00	18,121,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>201,170.00</b>	<b>202,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	201,170.00	202,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>864,000.00</b>	<b>10,636,805.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	9,441,605.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	1,195,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,755,651.00</b>	<b>2,411,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,491,541.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,264,110.00	2,411,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>118,536,160.98</b>	<b>57,173,000.03</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,908,500.00</b>	<b>29,220,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,508,500.00	27,820,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,400,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>9,517,479.29</b>	<b>9,843,992.55</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,517,479.29	9,843,992.55
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>78,110,181.69</b>	<b>18,108,407.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,110,181.69	18,108,407.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>23,962,400.00</b>	<b>18,984,900.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>23,962,400.00</b>	<b>18,984,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>23,962,400.00</b>	<b>18,984,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>23,962,400.00</b>	<b>18,984,900.00</b>

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,962,400.00	18,984,900.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-23,962,400.00</b>	<b>-18,984,900.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,639,970,000.00</b>	<b>1,621,747,576.74</b>	<b>18,222,423.26</b>	<b>98.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,639,970,000.00</b>	<b>1,621,747,576.74</b>	<b>18,222,423.26</b>	<b>98.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,606,598,000.00</b>	<b>1,592,526,976.74</b>	<b>14,071,023.26</b>	<b>99.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,256,024,300.00</b>	<b>1,249,717,306.00</b>	<b>6,306,994.00</b>	<b>99.5</b>
210101	Үндсэн цалин	809,329,500.00	824,216,146.86	-	101.8
210102	Нэмэгдэл	371,935,800.00	350,756,644.69	21,179,155.31	94.3
210104	Урамшуулал	74,759,000.00	74,744,514.45	14,485.55	99.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>170,435,200.00</b>	<b>163,633,399.02</b>	<b>6,801,800.98</b>	<b>96.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	118,339,000.00	116,259,568.49	2,079,431.51	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	13,024,000.00	12,891,732.48	132,267.52	98.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,419,300.00	10,047,945.77	371,354.23	96.4
210204	Ажилгүйдлийн даатгал	2,604,800.00	2,221,285.90	383,514.10	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	26,048,100.00	22,212,866.38	3,835,233.62	85.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>111,290,500.00</b>	<b>111,176,484.22</b>	<b>114,015.78</b>	<b>99.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	30,744,600.00	23,061,084.22	7,683,515.78	75.0
210302	Түлш, халаалт	65,798,300.00	81,612,880.00	-	124.0
210303	Цэвэр, бохир ус	14,747,600.00	6,502,520.00	8,245,080.00	44.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,062,200.00</b>	<b>13,949,232.50</b>	<b>112,967.50</b>	<b>99.2</b>
210401	Бичиг хэрэг	1,657,300.00	1,323,300.00	334,000.00	79.8
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	606,000.00	894,000.00	40.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,789,000.00	1,918,680.00	870,320.00	68.7

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	876,300.00	0.00	876,300.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	721,300.00	1,098,000.00	-376,700.00	152.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,518,300.00	9,003,252.50	-2,484,952.50	138.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,352,400.00</b>	<b>17,017,650.00</b>	<b>334,750.00</b>	<b>98.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,042,900.00	1,041,050.00	1,850.00	99.8
210502	Хоол, хүнс	10,699,500.00	10,536,700.00	162,800.00	98.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,610,000.00	5,439,900.00	170,100.00	96.97
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,522,300.00</b>	<b>32,521,600.00</b>	<b>700.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	18,122,300.00	18,121,600.00	700.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>579,500.00</b>	<b>202,000.00</b>	<b>377,500.00</b>	<b>34.8</b>
210702	Дотоод албан томилолт	579,500.00	202,000.00	377,500.00	34.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,998,900.00</b>	<b>1,996,705.00</b>	<b>2,195.00</b>	<b>99.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	803,700.00	801,505.00	2,195.00	99.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,195,200.00	1,195,200.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,332,700.00</b>	<b>2,312,600.00</b>	<b>20,100.00</b>	<b>99.1</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,332,700.00	2,312,600.00	20,100.00	99.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,372,000.00</b>	<b>29,220,600.00</b>	<b>4,151,400.00</b>	<b>87.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,372,000.00</b>	<b>29,220,600.00</b>	<b>4,151,400.00</b>	<b>87.5</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,972,000.00	27,820,600.00	4,151,400.00	87.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,639,970,000.00</b>	<b>1,621,747,576.74</b>	<b>18,222,423.26</b>	<b>98.8</b>

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,521,200,400.00</b>	<b>1,503,091,992.52</b>	<b>18,108,407.48</b>	<b>98.8</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	118,655,584.22	
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,521,200,400.00	1,503,091,992.52	18,108,407.48	98.8
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>118,769,600.00</b>	<b>118,655,584.22</b>	<b>114,015.78</b>	<b>99.9</b>
320001	Орон нутгийн төсвөөс	118,769,600.00	118,655,584.22	114,015.78	99.9
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>117.00</b>	<b>112.00</b>	<b>0.00</b>	<b>95.7</b>
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	72.00	67.00	0.00	93.0
620003	Үйлчлэх ажилтан	39.00	39.00	0.00	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>25,191,779.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>25,191,779.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,347,786.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>750,334.00</b>
210102	Нэмэгдэл	750,334.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,452.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,452.74
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,574,000.00</b>
210401	Бичиг хэрэг	653,000.00
210404	Ном, хэвлэл	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	521,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,250,000.00</b>
210602	Тавилга	2,250,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,600,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>99,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,843,992.55</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,843,992.55</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	9,843,992.55
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>25,191,779.29</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>25,191,779.29</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,774,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,417,779.29

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль /цаашид Мандал сумын 1 дүгээр сургууль гэх/ -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын тодруулга тайлан болон цахим төлбөрийн баримтын системийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв. Аудитын анхан шатны чанарын хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Эрүүл аюулгүй орчинд тэгш хүртээмжтэй сургалтын аргаар багш суралцагч эцэг эх хамтран тасралтгүй хөгжих бүтээлч багш, бие даасан зөв хүүхдийг төлөвшүүлэх ” гэж тодорхойлсон ба үйл ажиллагааны дараах чиглэлтэй байна. Үүнд:

- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлдэж үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Цахим нээлттэй хичээлийн сантай болж цахим хэрэглэгдэхүүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хүүхэд бүрийг бие даан суралцах, эрүүл зөв дадал хэвшилтэй болоход чиглүүлэн ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”;
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” журам тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,790.245.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,902.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,426.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,0 хувиар буюу 392,950.1 мянган төгрөгөөр өссөн ба өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн дүн материаллаг хэмжээний өөрчлөлттэй буюу 11.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,014.2	3,354.4	659.8
Бараа материал	208,819.5	207,196.4	(1,623.1)
Үндсэн хөрөнгө	3,341,487.4	3,736,721.2	395,233.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,554,321.0</b>	<b>3,947,271.9</b>	<b>392,950.1</b>
Богино хугацаат өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,554,321.0	3,947,271.9	392,950.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,554,321.0</b>	<b>3,947,271.9</b>	<b>392,950.1</b>

Тайланд онд 3,354.4 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага үүссэн нь өмнөх оноос 659.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 207,196.4 мянган төгрөг болж 1,623.1 мянган төгрөгөөр буурсан нь хүнсний болон барилгын засварын материалын эхний үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 159,666.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн бөгөөд 13,034.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 156,324.2 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,205,078.1 мянган төгрөг болж 161,532.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр 18,984.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан, сургуулийн барилга байгууламжид хийсэн их засварын ажлын 310,450.7 мянган төгрөгийн зардлыг барилга байгууламжийн дансанд капиталжуулсан, БШУЯ-наас 5,700.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,708.0 мянган төгрөгийн ном сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу 130,556.6 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн үнийг бууруулж, сумын ИТХ-ын 2021 оны 139 дугаар тогтоолоор 46,754.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 392,950.1 мянган төгрөгөөр өсөхөд үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,189,762.1 мянган төгрөг болж өмнөх оноос 355,080.9 мянган төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 4 дахин буюу 423,585.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилт 17.2 хувь буюу 17,653.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 1,796,735.1 мянган төгрөг болж өмнөх оноос 56,097.4 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр буюу нийт зарлагыг 1,583,797.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан бөгөөд 12 дугаар сард хийсэн нэмэлт өөрчлөлтөөр төсвийг 56,172.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **1,639,970.0** мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант хугацаанд Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны төсвийн хуваарьт дээд шатны байгууллагаас 3 удаа өөрчлөлт оруулсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 зориулалт, арга хэмжээний санхүүжилтэд 1,639,970 мянган төгрөг баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1,521,200.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 118,769.6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,521,200.4 мянган төгрөг төгрөг, орон нутгийн төсвөөс 118,655.6 мянган төгрөгийн нийт 1,639,856.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, урсгал үйл ажиллагааны зардалд 1,621,747.6 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 18,108.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,621,747.6** мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардал 13,108.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 114.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 113.0 мянган төгрөгөөр, нормативт зардал 334.8 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 377.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 2.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд “Боловсролын Чанарын Шинэчлэл” төслөөс 10,600.0 мянган төгрөг, аймгийн БСГ-аас үнэлгээний шалгалтын бичиг хэргийн зардлын санхүүжилт 653.0 мянган төгрөг, ариутгалын зардлын санхүүжилт 521.0 мянган төгрөг, сурах бичиг түрээсийн номны орлого 6,489.6 мянган төгрөг, гүнзгий ангийн сургалтын төлбөрийн орлого 2,844.0 мянган төгрөг, цахим тендерийн орлого 70.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлагаас 4,014.0 мянган төгрөг, нийт 25,191.7 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

1.БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “*Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын*

сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам"-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

2. Тайлант онд Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль БШУЯ-наас хэрэгжүүлж буй "E-FIRST" төсөл арга хэмжээнд хамрагдаж, төслийн хүрээнд 10,600.00 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан байна.

3. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь "0" үлдэгдэлтэй болсон 2,340.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 3 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 "...анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалттай нийцэхгүй байна. Иймд "0" үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 1,639,970.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,621,747.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.1 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөг/ зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1				1	-	-
Албан шаардлага	1	3,950.8	1	3,950,8	-	-	100
Төлбөрийн акт	1	644.0	1	644.0			100
Нийт	3		2		1		66,6

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2. Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн Юнитель, Скайтилийн төлбөрүүд орж шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,731.5 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

#### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

##### 1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

###### 1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 278.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

###### 2. Бараа материалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Бараа материалын тодруулга тайланд зардлын эдийн засгийн ангиллыг 6,453.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй бөгөөд “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэж, тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Мандал сумын 1 дүгээр сургууль	2	6,731.5							2	6,731.5
---	--------------------------------------	---	---------	--	--	--	--	--	--	---	---------